

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ НИЙСЛЭЛД
ТӨЛӨӨЛӨН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**
/Сүхбаатар дүүрэг/

2025.06.09

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2025 оны төсөв	Шалгуур үзүүлэлт	Хүрсэн түвшин, биелэлт
3.1. Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.				
3.1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар:				
3.1.1.1.	Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;	275,508,6	1.Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө-1 2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн бууралтын хувь	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, архины хамааралтай иргэдийн зан үйлд нөлөөлөх “Урам” төслийн төлөвлөгөөг Цагдаагийн 2 дугаар хэлтэстэй хамтран баталсан.
3.1.1.2.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах.		1.Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Цагдаагийн газрын 2 дугаар хэлтэстэй хамтран 10-20 дугаар хорооны 2 болон түүнээс дээш давтан дуудлагатай архины хамааралтай нийт 95 иргэнд сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулан гэр бүлд нь эргэн хяналт хийж, нөхцөл байдлыг тодруулан ажилласан.
3.1.1.3.	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Сэтгэл зүйн тусламж.үйлчилгээ авсан гэр бүлийн тоо	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан 394 хүүхэд, 69 насанд хүрсэн иргэнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан.
3.1.1.3.	Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал,	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Сэтгэл зүйн тусламж.үйлчилгээ авсан гэр бүлийн тоо	Нэг цэгийн үйлчилгээний төвөөр дамжуулан 43 хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг 24 цагаар үзүүлэн ажилласан.

	хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах			
3.1.1.4.	Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах;	Орон нутгийн төстийн хөрөнгөөр	1.Батлагдсан төсөв-100% 2.Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх	Хэлтсийн дэргэдэх Гэрч хохирогчийг хамгаалах Нэг цэгийн үйлчилгээний төвийн урсгалд зардалд Дүүргийн Засаг даргын Тамгын газраас 177.095.683 /зуун далан долоон сая ерэн таван мянга зургаан зуун наян гурван төгрөг/ санхүүлжилтийг авсан.
3.1.2. Хүүхдийн эрхийн талаар:				
3.1.2.1.	Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;	16,569,090,6	1. Төлөвлөгөө баталсан эсэх 2. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Хүүхдийн төлөө зөвлөлийн салбар дундын төлөвлөгөөг нэгтгэн ажилласан.
3.1.2.2.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх;		Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь	Ерөнхий боловсролын 27 сургуулийн “Хүүхэд хамгааллын баг”-аар дамжуулан 16,214 хүүхдэд үе тэнгийн дээрэлхэлт, хөгжлийн үйлчилгээг үзүүлэн ажилласан.
3.1.2.3.	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах;		Баталсан төсвийн хэмжээ	-Дүүргийн 14 Өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн шүдний 17 эмнэлэгтэй хамтран дүүргийн төр, хувийн хэвшлийн ерөнхий боловсролын 41 сургуулийн 1 дүгээр ангийн 3925 хүүхдээс шүд, амны хөндийн үзлэгт 3661 хүүхэд буюу 93,2% хамруулсан. Үүнээс 1737 хүүхдэд ховил хамгаалах ломбо тавьж, 571 хүүхэд шүдний эмчилгээнд хамрагдсан. -Дүүргийн 12-20 дугаар хорооны 150, 248, 36, 130, 171, 175, 109, 299, 225, 159, 205, 283, 51, 281 дугаар цэцэрлэгийн 1320 хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, шүдний эмчилгээ шаардлагатай хүүхдүүдийг эмчлэн эрүүлжилсэн. Эрүүлжилт 53%.

				-Зүрхний эмгэгийн илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт 3925 хүүхэд хамрагдсанаас 1005 хүүхэд зүрхний цахилгаан бичлэгт өөрчлөлттэй гарч, 744 хүүхдийг зүрхний хэт авиа оношилгоонд хамрууллаа.
3.1.2.4.	Орон нутгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах;		Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо	Сүхбаатар дүүргийн Хүүхдийн зөвлөлийн 15 удаагийн хурлыг зохион байгуулж хурал хийх байр танхимаар ханган ажилласан.
3.1.2.5.	“Олон нийтийн байцаагч”-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх.		1. Олон нийтийн байцаагчийн тоо 2. Илрүүлсэн хүүхдийн тоо	Дүүргийн хэмжээнд ажилладаг 20 олон нийтийн байцаагчийг чадавхуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан.
3.1.3. Хүүхэд хамгааллын талаар:				
3.1.3.1.	“Хүүхэд хамгааллын бодлого”-ыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх;		Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо	Дүүргийн хэмжээнд Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл байгуулж, хүүхэд хамгааллын бодлого боловсруулж хэрэгжүүлж буй 52 байгууллага аж ахуйн нэгж байгаа бөгөөд Монгол Оросын хамтарсан 3 дугаар сургууль, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, 29 дүгээр тусгай сургууль, Цагдаагийн 2 дугаар хэлтэс зэрэг 4 байгууллага дэргэдээ эцэг эхийн зөвлөл байгуулан хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлж ажилласан. Нийт 56 байгууллага аж ахуй нэгж Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл байгуулж, хүүхэд хамгааллын бодлого боловсруулж мөрдүүлж ажиллаж байна.
3.1.3.2.	Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх;		Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо	1-20 дугаар хорооны эрсдэлт нөхцөл дэх 288 хүүхдийн судалгааг авч нэгтгэн, эрсдэл өндөртэй 150 хүүхдийг Able программд бүртгэж, гэнэтийн ослын даатгалд хамруулсан. Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээний хүрээнд эрсдэлийн программд бүртгэлтэй, зорилтот бүлгийн нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн, хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдаж, хяналтад байгаа 107 хүүхдэд баярын бэлэг хүргүүлж ажилласан.
3.1.3.3.	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө		1. Орон нутгийн төсвөөс хуваарилсан	Дүүргийн “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-ны төлөвлөгөөг нэгтгэн 39 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон ажиллаж,

	баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх;		төсөв; 2. Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь	хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 10 хүүхдэд зан үйл засах 6 удаагийн сургалтыг байгуулан ажилласан.
3.1.3.4.	Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих;	7,379,967,0	1.Хяналт, шалгалтын тоо, 2.Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь	Дүүргийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/636 тоот “Хурдан морины унаач хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах тухай” захирамжийг гаргуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хурдан морь унаж уралддаг 2 хүүхдийн гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж, хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн.
3.1.3.5.	Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;		1 .Үйлчилгээ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо	Гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн төлөвлөгөөг боловсруулан ажилласан.
3.1.3.6.	Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх;		Осол гэмтлийн буурсан хувь	ТОХИЖИЛТООС
3.1.3.7.	Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар,			18 өдөр өнжүүлэх төв, 53 сүм хийдэд хүүхдийн эрхийн зөрчлийн зөчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсан.

	амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах.		Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь	
3.1.3.7.	Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах.			1-20 дугаар хороодод байрлалтай өдөр өнжүүлэх төв, зуслан, нэг цэгийн үйлчилгээний төв, хүүхэд хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 18 байгууллагуудад зөвлөн туслах ажлыг зохион байгуулан ажилласан. 1-20 дугаар хорооны хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 53 сүм хийдийн үйл ажиллагаанд хяналт тавьж арга зүйн зөвлөгөө өгч хүүхэд хамгааллын бодлогын талаар арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.
3.2. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажил/хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана;				
3.2.1. Хөдөлмөрийн харилцааны талаар:				
3.2.1.1.	Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах;	19,251,038,8	Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо	Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар зөвлөн туслах, хууль сурталчлах ажлууд хийгдсэн. ХАБЭА-н салбар зөвлөлөөс боловсруулсан албан даалгавар 1-20 хороонд хүргэгдсэн. Хамрагдсан байгууллагын тоо 100
3.2.1.2.	Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;		1.Хамрагдсан ААНБ-ын байгууллагын тоо 2.Зохион байгуулсан сургалтын тоо	ХАБЭА-н салбар зөвлөлийн цахим хуудсаар “Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр-т хамрагдах танилцуулга, сурталчилгааг” нээлттэй мэдээлсэн. Мэдээлэл авч, зөвлөх үйлчилгээнд хамрагдах хүсэлт ирүүлэх тухай мэдэгдсэн байгууллагын тоо 10, ХАБЭМТ-тэй хамтарсан 1 удаагийн сургалт, хэлэлцүүлэгийн арга хэмжээнд 11 ЖДҮ эрхлэгчдийг дэмжин оролцуулсан.
3.2.1.3.	Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр,		Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо	Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд нийт 110 маргаантай өргөдөл ирүүлснээс 102 гомдлын асуудлаар ажил олгогч ажилтан эвлэрээгүй, 8 гомдлын талууд эвлэрсэн

	хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;			шийдвэр гарсан байна. Нийт хуралдсан тоо 15, хуралдсан цаг 163 цаг.
3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:				
3.2.2.1.	2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах;	15,466,849,8		
3.2.2.2.	Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах;		2. Судалгаа, мэдээллийн тоо	
3.2.2.3.	Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;		Судалгаа, мэдээллийн тоо	
3.2.2.4.	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж		1.АЙМГИЙН ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, халамжаас хөдөлмөрт шилжүүлэх зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж

	ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах;		үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь 2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь 3.Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө, гүйцэтгэлийн өсөлтийн хувь	байгаа өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажилтай болгох зорилгоор 13,16 дугаар хорооны зорилтот бүлгийн 71 иргэнд сургалт зохион байгуулж, 20 иргэнд үнэлгээ хийж бүртгэл хийсэн. Үүний үр дүнд 3 иргэн байнгын ажлын байранд зуучлагдсан. Танхимын болон цахим ур чадвар олгох сургалтад зорилтод бүлгийн нийт 11 иргэнийг бүртгэн сургахаар төлөвлөн ажиллаж байна.
3.2.2.5.	Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртөй, инновац шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;		1.Холбогдох арга хэмжээний тоо 1.Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ Д.Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашигтай загварын тоо	
3.2.2.6.	Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;		Холбогдох арга хэмжээний тоо	Дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн төлөвлөгөөг ... арга хэмжээг төлөвлөн гүйцэтгэлийг ханган ажиллаж байна.

3.2.2.7	Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах.		1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 3.Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо	1.Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах ёстой орон тоондоо ажиллуулаагүй 15 аж ахуйн нэгжээс 243,455,520 төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн.
3.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар:				
3.2.3.1.	Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн, зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх.	Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоол “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу 28 байгууллагын 28 иргэний үйлдвэрлэлийн ослын актыг /inspection.hudulmur-halamj.gov.mn/ цахим бүртгэлд бүртгэж, хянаж баталгаажуулсан. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 4 дуудлагаар ажиллаж, холбогдох байгууллагад илтгэх хуудсыг хүргүүлсэн. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 4 дуудлагаар ажиллаж, холбогдох байгууллагад илтгэх хуудсыг хүргүүлсэн.
3.2.3.2.	Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Төлөвлөсөн төсөв 2.Зохион байгуулсан арга хэмжээний тоо	- Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламжийн сургалтыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын удирдлагууд, дэргэдэх хэлтсийн дарга, алба хаагчид, 1-20 дугаар хороодын Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нийт 75 хүнийг хамруулан зохион байгуулсан.

	хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах;			- Дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлийн 11 гишүүнийг чадавхжуулах сургалтад хамруулж, сертификат олгосон. - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг хүрээнд аж ахуй нэгж, байгууллага, иргэний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл ажлын орчин бүрдүүлэх, аливаа аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, нийгмийн хариуцлагаа биелүүлж ажиллахыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 1320 ажил олгогчдод анхааруулж, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах тухай Засаг даргын орлогчийн 2025 оны 04 дүгээр сарын 09-ны 06 дугаар албан даалгаврыг хүргүүлж ажилласан.
3.2.3.3.	Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг авран хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээг авах.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Төлөвлөсөн төсөв 2.Тухай бүр авсан арга хэмжээний тоо	
3.3. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.				
3.3.1 нийгмийн даатгалын талаар:				
3.3.1.	Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулах		нийгмийн даатгалын сайн дураар даатгуулагчийн өсөлтийн хувь	Тайлант хугацаанд сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд хамруулах, нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулахаар тус газрын даргын баталсан сургалт хөтөлбөрийн дагуу шат дараалсан арга хэмжээг авч байгаа бөгөөд үүний үр дүнд сайн дурын даатгалд шинээр 1015 даатгуулагч, 0-3 насны хүүхдээ асарч буй эх 95, малчин 1, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг /эх/ 102 даатгуулагчийг тус тус хамруулсан байна.
3.3.1.2	нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх		цахим хэлбэрт шилжүүлсэн	Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор цахимжуулалтыг эрчимжүүлэх ажлыг шат дараалан хийж байна. Үүнд:

	зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	19,301,742,3	тэтгэврийн хувийн хэргийн эзлэх хувь	Тус газар нь архивын үйлчилгээг сайжруулах зорилгоор дүүргийн хөрөнгө оруулалтаар 38536000 (Гучин найман сая таван зуун гучин зургаан мянга) төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/19 дугаартай тушаалаар “Ухаалаг цахим архивын тоног төхөөрөмж болон дагалдах үйлчилгээ худалдан авах”, нийлүүлэх тендерийг шалгаруулах үнэлгээний хороог байгуулан гүйцэтгэгчийг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж шаардлагатай тоног төхөөрөмжийг хүлээн авч нийгмийн даатгалын байгууллагын архивын баримтуудаас эхний ээлжид тэтгэврийн хувийн хэргийг цахижуулах зорилгоор баримтуудыг скайнердаж мэдээллийн сан бүрдүүлэх, чип суулгах зэрэг ажлуудыг хийж эхэлсэн. Сүхбаатар дүүргийн нийт 20 хорооны 1-7 дугаар хорооны тэтгэвэр авагчийн хувийн хэргийн материалыг скайнердаж бүрэн дуусгасан бөгөөд 24360 тэтгэврийн хувийн хэргийг бүрэн чипжүүлээд байна. Мөн нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор архивын лавлагаа, мэдээллийг хүсэлтийн дагуу дотоод сүлжээ, able программыг ашиглан солилцож байна. Тайлант хугацаанд орон нутаг болоод аймаг дүүргийн нийгмийн даатгалын газар луу хүсэлтийн дагуу 261 лавлагаа, мэдээллийг цахимаар солилцож иргэд даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг хурдан шуурхай, чирэгдэлгүй хүргэсэн байна.
3.3.1.3	даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд төрийн байгууллага хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, төсвийн байгууллага өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад хамтран ажиллах дэмжлэг үзүүлэх		нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо	Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын Шимтгэл Хураалт Удирдлага, Арга зүйн газартай хамтран удирдамжийн дагуу 100 сая төгрөгнөөс дээш өртэй төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өртэй аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж өр барагдуулах гэрээ, албан шаардлага өгч цаашид авлага үүсгэхгүй талаар анхааруулж зөвлөмж өгч ажилласан. Үүний үр дүнд төсөвт байгууллагын шимтгэлийн өр 298 сая төгрөгөөр барагдаж, орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өр 59 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.
3.3.1.4	хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах,		хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо	

	хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьчилан сэргийлэхэд, эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах			
3.3.1.5	хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах		зохион байгуулсан арга хэмжээний тоо	
3.3.2. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн талаар:				
3.3.2.1.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг өрхийг хамруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үүнээс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо	
3.3.2.2.	Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг орон нутагтаа холбогдох талуудыг оролцуулан зохион байгуулах, архинаас гаргах дэмжих бүлгүүдтэй хамтран ажиллах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Дэмжих бүлгийн тоо, архинаас гарсан иргэний тоо, үүнээс хөдөлмөр эрхэлж тогтмол ажлын байртай болсон хүний тоо	
3.3.2.3.	Нийгмийн ажилтнуудын бусад салбарын хамтран ажилтнуудтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах,	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, 2. сургалтын тоо	

	чадавхжуулах сургалтад тогтмол хамруулах.			
3.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар:				
3.3.3.1.	Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Сургалт	Дүүргийн Эрүүл мэндийн төвөөс иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох урт, богино хэмжээний 7 видео контентийг гаргаж, цахим хуудаст байршуулан 17,164,000 орчим иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан.
3.3.3.2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	ажил чиг үүрэгт байхгүй
3.3.3.3.	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Зохион байгуулсан сургалтын тоо	“Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” аяны хүрээнд дүүргийн Эрүүл мэндийн төв 29 дүгээр сургуулийн үе тэнгийн сургагч багш нартай хамтран Нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн ариун цэвэр, Бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх сэдвийн хүрээнд 2 удаагийн сургалт зохион байгуулж, 58 сурагч хамруулсан.
3.3.3.4.	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэхэд төрийн болон ТББ-тай хамтран ажиллах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Дэмжих төв	Засгийн газраас 2025 онд хавсарсан, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эх, асран хамгаалагчид олгож байгаа асаргааны тэтгэмжийг нэмэгдүүлэн олгох болсонтой холбоотойгоор хавсралтаар ирсэн оношийн жагсаалтын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг гарган, шалгуур үзүүлэлтийг баримталж, хүүхдийн хувийн хэрэг болон өрхийн эмч нарын судалгаанд тулгуурлан, хавсарсан, хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн жагсаалтыг гаргасан. Тодруулга шаардлагатай үед өрхийн эмнэлгийн эмч, халамжийн мэргэжилтнүүдтэй тухай бүр холбогдож ажиллалаа. Оношийн жагсаалтын дагуу гаргасан 588 хүүхдийн хувийн хэргийг шалгаж, өрхийн эмч нараас тодруулга авч, 249 хүүхдийг хавсарсан хүнд хэлбэрийн гэж тодорхойлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын тодорхойлолтыг дахин гаргаж ажилласан. Хүнд хэлбэрийн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа эцэг, эх, асран хамгаалагчдад “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”-ий сургалт зохион байгуулах

				үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах ажлын хүрээнд 2025 онд 20,550,000 төгрөгийн санхүүжилтийг хуваарилан, үйлчилгээг үзүүлэх байгууллага сонгон шалгаруулах тендерийг 2025 оны 05 дугаар сарын 15-ы өдөр зарлаж, тендерийн нээлтийг 2025 оны 06 дугаар сарын 05-ы өдөр хийсэн.
3.3.3.5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх,	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2025 оны эхний хагас жилд 16 удаа хуралдаж, 526 хүүхэд хамрагдсанаас асаргааг шинээр тогтоолгосон 46 хүүхэд, хугацаа алдсанаас дахин тогтоолгосон 12 хүүхэд, асаргааг сунгасан 133 хүүхэд, оношоос хамаарч хичээлийн програмыг бие болон сэтгэхүйн онцлогт тохируулах тодорхойлолт авсан 12 хүүхдийн бэрхшээлийг тодорхойлон, эмнэлгийн тодорхойлолт гарган, үйлчилгээнд бүрэн хамруулан ажилласан. 16 наснаас 19 нас хүртэлх хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг салбар комиссоос тогтоох болсонтой холбоотойгоор 18 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоож, 8 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолтыг сунгаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт хамруулсан. Онош тохирохгүй болон асаргааны хугацаа дуусаагүй шалтгаанаар 27 хүүхдийг буцааж, 1 хүүхдийг цуцалсан. 264 хүүхдийн оношийг хүнд хэлбэр мөн эсэхийг тодорхойлсон. Шинээр асаргааны үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдүүдийн асран хамгаалагч нарт эрүүл мэнд, боловсрол, халамжийн үйлчилгээний талаар мэдээлэл хүргэж, гарын авлага тарааж байна. ХБХЭМБНХСК-ын хурал зохион байгуулах хуваарийг шинэчилж, ХБХЭМБНХСК-ын даргаар батлуулж, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт хүргэн ажилласан. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдэд зориулсан хавсарсан болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийн талаар цахим сургалт, комиссын нарийн бичгийн дарга нарт чиглэл хүргүүлэх цахим сургалт, хавсарсан болон хүнд хэлбэрийн оноштой хүүхдүүдийг программд бүртгэх тухай цахим сургалт, боловсролын цахим сургалтад тус тус хамрагдсан.

3.3.3.6.	Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Нийгмийн ажилтны чиг үүрэг байгаа-
3.3.3.7.	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлын Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	
3.3.3.8.	Хөдөлмөрийн хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Гэрээ байгуулан хамтран ажилласан ТББ-ын тоо	15 аж ахуй нэгжтэй хамтран 245,039,520 төгрөгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний авч ажиллуулаагүй төлбөр төвлөрүүлэн ажиллаж байна.
3.3.3.9.	Орон нутгийн цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудасны тоо	Ажлын чиг үүрэгт хамааахгүй-
3.3.3.10.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар, байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 20 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилт 60 хувьтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 60 хувьтай байна.
3.3.3.11.	Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо Үүнээс: эхний ээлжинд	-Дүүргийн Эрүүл мэндийн төвийн харьяа Сэлбэ эмнэлэгийн 1, 2 дугаар давхруудад харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөтөч зам, Брайль үсгэн дуугүй хөтөч чиглүүлэх ном байршуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх утгах ажилтан, эмч, эмнэлгийн ажилчдад зориулсан дохионы хэлний сургалт, дохионы хэлний

			НДГ, ХХҮГ, ХГБХХГ, Нэг цэгийн үйлчилгээний төв	аппликейшн суулгах зэрэг ажлыг хийж гүйцэтгэн тохируулгат орчны хүртээмжийг нэмэгдүүлсэн. -Дүүргийн нэг цонхны үйлчилгээгээр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, жирэмсэн болон бага насны хүүхэдтэй иргэдэд зориулан өрөө гаргаж, засварлан, хүүхэд хуурайлах тавцан, зөөврийн ширээ, буйдан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан салбар зөвлөлийн мэдээллийн самбар, брайль болон хөгжлийн бэрхшээлийн ойлголтыг нэмэгдүүлэх номнууд, анхны тусламжийн гарын авлага, төрөл бүрийн танин мэдэхүй, соёлын ном, хүүхдэд зориулсан зурагт, англи хэлний номнуудаас бүрдсэн номын тавиур, сандал, зөөлөн дэвсгэр, анхны тусламжийн эмийн хайрцаг, нэг удаагийн аяга, ариун цэврийн хэрэгслэлүүд, ханын шүүгээ зэргээр тохижуулж ээлтэй орчинг бүрдүүлж ажилласан.
3.3.3.12.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах.	-	Хөгжлийн төвийн тоо	-
3.3.4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар:				
3.3.4.1.	Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна.	Орон нутгийн төстийн хөрөнгөөр	1.Сургалт, мэдээллийн тоо 2,Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо	-Цагдаагийн газраас ерөнхий боловсролын 4 сургуулийн ахлах ангийн 1100 сурагчдад жендерийн тухай ойлголт, хорт зуршил, цахим орчинд хэрхэн өөрийгөө хамгаалах талаар мөн үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх агуулгын хүрээнд сургалтыг зохион байгуулсан. - Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2.310.000 төгрөгийг шийдвэрлүүлж үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор 90х60 хэмжээтэй 40 ширхэг сурталчилгааны самбарыг хэвлүүлэх ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд байршуулсан. -Мөн 3 төрлийн постер, 1 рийл, Монголын улсын хүүхэлдэйн театрын уран бүтээлчидтэй хамтран шторк 1 хийж Цагдаагийн газрын цахим хуудас болон дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын цахим хуудас, группт байршуулан иргэд олон нийтэд мэдээлэл хүргэсэн.
Ахмад настны талаар				
3.3.5.1.	Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил 2	-Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан дүүргийн харъяа байгууллагууд, хэлтэс албад болон сургууль, цэцэрлэгээс тэтгэвэрт гарсан ахмадуудын төлөөлөл, 1-20 дугаар хороодын Засаг дарга, нийгмийн ажилтнууд нийт 86 иргэнд дүүргийн Ахмадын хороо,

				Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэндийн төв, Нийгмийн даатгалын газар, Насан туршийн суралцахуйн төв, Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын хэлтэс, Тэтгэврийн дараах ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв ТББ-аас ахмад настны талаар авч хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагаа, шинэчилсэн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, холбогдох бусад хууль дүрэм, журамд орсон нэмэлт өөрчлөлт, онцлог заалтуудын талаарх сургалтыг зохион байгуулсан. -Дүүргийн Ахмадын хороо 1-10 дугаар хорооны ахмадын зөвлөлийн дарга нартай хамтарч 1-10 дугаар хорооны 120 ахмад настанд Ахмад настны тухай хуулийн шинэчлэл өөрчлөлт, тус хэлтсээс үзүүлсэн үйлчилгээний танилцуулга зэргийг хийж хууль журмын шинэчлэлтийг сурталчлан таниулах, арга хэмжээг зохион байгуулсан.
3.3.5.2.	Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ААНБ-тай хамтран ажиллах, хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1 Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо, 2.Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллагын тоо	Дүүргийн 2026 оны төсөвт Ахмадын сан байгуулах төсвийг суулгахаар төлөвлөж байна.
3.3.5.3.	Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон, өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, Ахмадын өргөөг ахмад настан бүрт нээлттэй байх талаар анхаарч ажиллах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1. Баталсан төсвийн хэмжээ /сая.төг/ 2.ҮЙЛЧИЛГЭЭНД хамрагдсан ахмад настны тоо	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Ахмадын хөгжлийн төвийг барьж ашиглалтад оруулан төвийн гүйлтийн зам, фитнес дугуй, цана бүсэлхийн массаж, нурууны дасгалын төхөөрөмж бүхий сэргээн засах танхим, массажны ор, бумба, хаш чулуун гудас, гүйфурен сандал зэрэг төхөөрөмж бүхий хөдөлгөөн дэмжих танхим, урлаг заал, өдөр өнжүүлэх танхимаар 3864 гаруй ахмадад чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн байна.
3.3.5.4.	Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих төвийг байгуулж, ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	ҮЙЛЧИЛГЭЭНД хамрагдсан тоо	

3.3.5.5.	Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Цогц үнэлгээнд хамрагдсан ахмад настны тоо	
3.3.5.6.	Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавих;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх 2.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо	Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага сонгон шалгаруулах тендерийг 2025-05-15-ны өдрөөс нээлттэй зарласан бөгөөд сонгон шалгаруулалт дуусаж гэрээ байгуулсны дараа ахмадын үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй ахмадуудад үнэлгээ хийж, тусламж үйлчилгээ үзүүлэх ажил хийгдэнэ.
3.3.5.7.	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах;	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1.Бүх шатны боловсролын байгууллагад сургалт хийсэн ахмад настны тоо 2.Ажиллаж байсан байгууллагадаа сургалт хийсэн ахмад настны тоо	153 ахмад
3.3.5.8.	Ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	1. Журам баталсан эсэх 2.Оршуулах үйл ажиллагаанд	Оршуулгын тэтгэмжийг 12 ахмад настанд 24,000,000 төгрөгийг олгосон.

	ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг хэрэгжүүлэх;		зарцуулсан зардлын хэмжээ /сая төг/	
3.3.5.9.	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна.” гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах, хяналт тавих;		50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо, үүнээс ажиллаж байгаа ахмад настны тоо	Хяналт шалгалтад хамрагдсан ААНБ-уудад Хөөдлмөртийн тухай хуулийн 2025 оны 01 дүгээр сараас хэрэгжиж буй Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна.” заалтыг сурталчилан, урьдчилан сэргийлж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байгаа.

-----oOo-----